МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА /ИНФО ГРАФИК/

# I.АСУУДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД **11** УДАА НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН /**30 ХУВЬД**/.
- ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТЭРСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ НЭМЭГДСЭН.
- УУЛ УУРХАЙ, АВТО ЗАМ, ТӨМӨР ЗАМ, БОЛОВСРОЛ, ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН САЛБАР, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАХИАЛГААР ХИЙГДЭЖ БУЙ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖЛУУДАД ХЯНАЛТ БАЙХГҮЙ. /АЖЛЫН ДАВХАРДАЛ, НАРИЙВЧЛАЛЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ АЖИЛ ХИЙГДЭЖ, НЭГДСЭН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ ХУУЛИЙН ЗААЛТ ХЭРЭГЖДЭГГҮЙ/
- УЛС ОРНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ **ДУНД** БОЛОН **ТОМ МАСШТАБЫН** БАЙР ЗҮЙН ЗУРГИЙГ НИЙТЭД ХЭРЭГЛҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.
- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ** БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ ТОДОРХОЙГҮЙ.
- УИХ-ААР БАТЛУУЛАХ ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ХЯНАХ ТОГТОЛЦОО ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИНД БҮРДЭЭГҮЙ.
- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ХИЙХ НАРИЙВЧИЛСАН ЗОХИЦУУЛАЛТ БАЙХГҮЙ.
- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХАРИЛЦААГ **60** ГАРУЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТААР ЗОХИЦУУЛЖ БАЙНА. **12** ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ, **3** ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА ҮҮССЭН.
- ХУУЛИЙН ТӨСЛИЙГ **12** УДАА, **5000** ГАРУЙ ХҮНИЙ ОРОЛЦООТОЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭН, **200** ГАРУЙ САНАЛЫГ ТУСГАСАН.
- УИХ-ЫН d-parliament САЙТАД ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ АВАХААР БАЙРШУУЛСАН.
- **100** ГАРУЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС САНАЛ АВЧ ТУСГАСАН.

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

**АГУУЛГА:**
6 Бүлэг
32 Зүйл
169 Хэсэг
236 Заалт

| | |
|---|---|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ | НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ | ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ | ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ | ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ |
| ТАВДУГААР БҮЛЭГ | ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО |
| ЗУРГААДУГААР БҮЛЭГ | САНХҮҮЖИЛТ, ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРИУЦЛАГА |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

**ХУУЛИЙН ЗОРИЛТ**

ГАЗАР, ТҮҮНИЙ ДООР, ДЭЭР, АГААРЫН ОРОН ЗАЙД ХИЙГДЭХ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ ХОЛБОГДСОН БУСАД ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХАД ОРШИНО.



## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- СОЛБИЦЛЫН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ХЭМЖИХ, ЗУРАГЛАХ
- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН БАРИМТЫГ АШИГЛАХ
- БАЙНГА ШИНЭЧЛЭГДЭХ МЭДЭЭЛЛЭЭР ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ

**Гадаадын хуулийн этгээд, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.**

## ХУУЛИАР ЖУРАМЛАСАН АСУУДЛУУД

- **Газрын зургийн төрөл, ангилал, агуулга, нарийвчлал, хэрэглээ**
- **Геодезийн цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүс**
- **Хариуцах, хэрэгжүүлэх субьект**
- **Тусгай болон нийтийн зориулалттай байр зүйн зураг**
- **Хянах, шалгах, шинэчлэх,мэдээллийн санд шилжүүлэх**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ

**Улсын Их Хурал:**
- улсын хилийн шугамын дагуух байр зүйн зураг, хилийн тэмдэгтийн солбицол, өндөр, хилийн цэсийг батлах:
- 1:25000-аас багагүй масштабтай газрын зурагт дүрсэлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зураг, солбицлын жагсаалтыг батлах:

**Засгийн газар:**
- улсын хилийн шугамыг хамтран шалгах, хилийн бүсэд агаарын зураг авах, байр зүйн зураг үйлдэх ажлыг удирдан зохион байгуулах

**Засгийн газар**
- Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлыг зохион байгуулах журмыг батлах

**Улсын их хурал:**
- байр зүйн зургийн нууцын зэрэглэл тогтоох, нууцыг ил болгох

**Засгийн газар:**
- Газрын зураг зохиох, шинэчлэх, хэвлэх, ашиглах журам

**БХБЯ:**
- Газрын зургийн агуулга, тавигдах шаардлагыг батлах

**ГЗБГЗЗГ:**
- Тусгай зориулалтын газрын зураг, сургалт, нийтийн хэрэгцээний газрын зураг, атлас, үндэсний атлас,
- газрын зургийн нэг маягийн суурь
- сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын эхэд мэргэжлийн дүгнэлт өгөх

**Засаг дарга:**
- Том масштабын газрын зураг зохиох, шинэчлэх

**Захиалагч:**
- Суурь мэдээлэл ашиглах, ГЗЗ-н ажлын үр дүнг нэгдсэн сан, хөмрөгт үнэ төлбөргүй шилжүүлэх




**Боловсруулах:**
ГЗБГЗЗГ

**Батлах:**
Засгийн газар

**Засгийн газар:**
- геодезийн эхлэл цэгийн өгөгдөхүүнийг батлах,

**БХБЯ:**
- Улсын геодезийн сүлжээ, байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, нягтруулах

**ГЗБГЗЗГ:**
- геодезийн хэмжилтийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээ байгуулах, өргөтгөх, хэвийн ажиллагааг хангах, ашиглуулах

**Засаг дарга:**
- Том масштабын газрын зурагт зориулсан геодезийн сүлжээ

**Засгийн газар:**
- Байнгын ажиллагаатай суурин станцын хамгаалалтын зурвас
- геодезийн сүлжээний эхлэл цэгийг хамгаалалтад авах

**Бүрэн бүтэн байдлыг хариуцах:**
- ГЗБГЗЗГ
- ХХЕГ
- Улсын тусгай хэрэгцээний газар эзэмшигч
- Сум, дүүргийн Засаг дарга

УИХ батлах:
- Байгалийн объектын нэр;
- улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот тосгоны нэр, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр.

Тухайн шатны ИТХ батлах:
- Хүний үйл ажиллагаагаар бий болсон объектын нэр.

**Засгийн газар:**
- газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;
- газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, газар зүйн нэрийн зураг үйлдэх үйл ажиллагааны журмыг батлах

**Засаг дарга:**
- газар зүйн нэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

2

## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ШИНЭЧЛЭХ ХУГАЦАА:

### 1 УЛСЫН ГЕОДЕЗИЙН СҮЛЖЭЭ

УЛСЫН БАЙРЛАЛЫН СҮЛЖЭЭ
(8-10 жил)



ӨНДРИЙН БОЛОН ГРАВИМЕТРИЙН СҮЛЖЭЭ
(15 жил)



ОРТОФОТО
(1-3 жил)



ГАЗРЫН ЗУРГИЙН НЭГ МАЯГИЙН СУУРЬ
(ҮНДСЭН 7-Н ДАВХАРГА )



### 2 ГАЗРЫН ЗУРАГ

ДУНД МАСШТАБЫН БАЙРЗҮЙН ЗУРАГ
1:10000 – 1:200 000 (10 жил)



ТОМ МАСШТАБЫН БАЙРЗҮЙН БОЛОН ДЭВСГЭР ЗУРАГ 1:100 – 1: 1000
(2-3 жил)



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АТЛАС
(10 жил)



ГАЗАРЗҮЙН НЭР (20 жил)



30
ХОНОГТ

- ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ
- ШИЛЖҮҮЛЭХ
- ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

27.8. Хүн, хуулийн этгээд нь энэ хуулийн 27.4.2-д заасан мэдээллийг мета-өгөгдлийн хамт ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор геодези, зураг зүйн мэдээлийн улсын нэгдсэн санд шилжүүлэх үүрэгтэй.

24.19. Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтийг, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт цахим системээр дамжуулан гаргана.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

10

## ГАЗРЫН ЗУРГИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ, АГУУЛГА, НАРИЙВЧЛАЛ, ХЭРЭГЛЭЭ

**ГАЗРЫН ЗУРГИЙН ТӨРӨЛ:**

- байр зүйн зураг;
- дэвсгэр зураг;
- хаягийн зураг;
- гүйцэтгэлийн зураг;
- кадастрын зураг;
- газар зүйн нэрийн зураг;
- ортофото зураг;
- сэдэвчилсэн газрын зураг, атлас;
- жижүүрлэлтийн зураг;
- бусад.

**том масштабын:** 1:100, 1:200, 1:500, 1:1000, 1:2000, 1:5000

- геологийн нарийвчилсан судалгаанд 1:2000;
- хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны газар хөдлөлийн бичил мужлалын зураглалд 1:1000, 1:5000;
- барилгажсан талбайн байр зүйн болон дэвсгэр зурагт 1:500, барилгажаагүй талбайн байр зүйн дэвсгэр зурагт 1:1000;
- төв суурин газрын хаягжуулалтад 1:1000,
- хот суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтөд 1:1000-1:2000;
- газар доорх болон гүүрэн байгууламж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шугамын суурилуулалтад 1:100-1:200;
- хот орчмын бүс болон орчны тойм зургийг нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааран 1:5000 - 1:25000;
- инженерийн барилга байгууламжийн нарийвчилсан төлөвлөлтөд 1:200-1:1000.

**дунд масштабын:** 1:10000, 1:25000, 1:50000, 1:100000, 1:200000

- Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулахад 1:25000, 1:50000, 1:100000;
- бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд 1:100000-1:500000;
- аймаг, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлтөд 1:25000-1:100000;
- усны нөөцийн тархалт, улсын геологийн эрэл хайгуулд 1:200000;
- геологийн ерөнхий эрэл хайгуулын судалгаанд 1:25000;
- бэлчээр, газар тариалан, авто зам, эрчим хүч, хийн хоолой, төмөр замын трассын төлөвлөлтөд 1:10000-1:25000;
- төв суурингаас бусад газрын хаягжуулалтад 1:100000;
- газар зүйн нэрийн зураг зохиоход 1:25000-1:100000;
- хот орчмын бүс болон орчны тойм зургийг нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааран 1:5000 - 1:25000;

**жижиг масштабын:** 1:500000 ба түүнээс жижиг масштаб

- улсын хэмжээний байгаль, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг дүрсэлсэн сэдэвчилсэн газрын зураг, атласт жижиг масштабын;
- бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд 1:100000-1:500000;

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

## 11 ГАЗАР ЗҮЙН НЭР

Хэлэлцэх

Батлах

УУЛ, НУРУУ, БУЛАН, ТОХОЙ, АРАЛ, ХОЙГ, ХЭЭР ТАЛ, ГОВЬ, ЦӨЛ, ГОЛ, МӨРӨН, НУУР, ТОЙРОМ ЗЭРЭГ ФИЗИК ГАЗАР ЗҮЙН ОБЪЕКТ

УЛС, ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ХОТ ТОСГОНЫ НЭР, УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН НЭР

ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ → ЗАСГИЙН ГАЗАР → УЛСЫН ИХ ХУРАЛ

ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГААР БИЙ БОЛСОН ДАЛАН, ГҮҮР, УСАН САН, СУВАГ, ХӨШӨӨ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗАР, ГУДАМЖ, ЗАМ, ТАЛБАЙ, ХОТХОН, ХОРООЛОЛ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭР, ТЭЭВЭР, ХОЛБОО ЗЭРЭГ БУСАД ОБЪЕКТ

ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ
- аймаг,
- нийслэл,
- сум,
- дүүрэг

ТУХАЙН ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## 12 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- Техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл;
- геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах, шүүмж хийх, хянан тохиолдуулга хийх;
- геодези, зураг зүйн ажилд техникийн хяналт хийх, ажлын чанарт зөвлөгөө, дүгнэлт гаргах;
- техник, технологийн үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох;
- багаж, тоног төхөөрөмжийн угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах;
- өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн ашиглалт.

## 13 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН ДААТГАЛ

- Учирч болзошгүй эрсдлийг даатгуулж болно.
- Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулж болно.
- Ажилтнуудыг амь насны даатгалд даатгуулж болно.

## 14 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ

Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг:
- геодези, зураг зүйн норм дүрэм /заавал мөрдөнө/;
- журам, заавар, аргачлал;
- стандарт.

## 21 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

ТББ-аар гүйцэтгүүлж болно:
- салбарын ажилтны давтан сургалт.
- мэргэшлийн зэрэг олгох сургалт .
- захиалагчийн техникийн хяналт, магадлал, магадлан хэмжилт хийх.

## 23 БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭНИЙ ҮҮРЭГ

- Учирч болзошгүй эрсдлийг даатгуулж болно.
- Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулж болно.
- Ажилтнуудыг амь насны даатгалд даатгуулж болно.

## 22 ЗАХИАЛАГЧИЙН ЧИГ ҮҮРЭГ

- Захиалагч нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр геодези, зураг зүйн ажлын үр дүнг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан, хөмрөгт үнэ төлбөргүй шилжүүлэх үүрэгтэй;
- энэ хуулийн 27.4-д заасан нэгдсэн санд байгаа суурь мэдээллийг ашиглах;
- геодези, зураг зүйн ажилд магадлал, захиалагчийн техникийн хяналт хийлгэж, холбогдох зардлыг хариуцах;

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

## 24 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- тусгай зөвшөөрлийг геодезийн, зураг зүйн гэж хоёр төрлөөр таван жилийн хугацаатай олгох,
- суурь нөхцөл, шаардлага:
  - геодезийн бакалавр зэрэгтэй хоёроос доошгүй инженертэй, нэг нь зөвлөх эсхүл мэргэшсэн зэрэгтэй байх
  - электрон тахеометр, хиймэл дагуулаас байрлал тодорхойлох хоёр долгионы багаж, нивелир,
- Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь зураг зүйн зөвлөх эсхүл мэргэшсэн зэрэгтэй, боловсруулалтын техник, програм хангамжтай байх,
- Тусгай зөвшөөрөл хүсэх, олгох, сунгах, түтгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журамд нийцүүлэн зохион байгуулах,
- Гадаадын хуулийн этгээд, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

## 25 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТӨРИЙН ХЯНАЛТ

- геодези, зураг зүйн талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан норматив баримт бичгийн биелэлтийг хангуулна.
- улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэлд ажиллах геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.
- хяналтын улсын байцаагчаар геодези, зураг зүйн мэргэжилтэй, мэргэжлээрээ ажиллаж зохих дадлага туршлага эзэмшсэн иргэнийг томилно.

## 26 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖИЛД МАГАДЛАЛ, МАГАДЛАН ХЭМЖИЛТ, ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХИЙХ

**1 МАГАДЛАЛ**

- техник, эдийн засгийн үндэслэл,
- техникийн төсөл, ажлын даалгавар,
- сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын болон хэвлэлийн эх

**2 МАГАДЛАН ХЭМЖИЛТ**

- геодезийн хэмжилтийн үр дүнг шалган магадлах зорилготой

**3 ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ**

- геологийн болон гидрогеологийн дунд масштабын зураглалд ашигласан геодези, зураг зүйн суурь өгөгдөл, мэдээлэл болон хэмжилт зураглалын ажил;
- уул уурхайн ашиглалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад ашигласан геодези, зураг зүйн суурь өгөгдөл, мэдээлэл болон хэмжилт зураглалын ажил;
- байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө зохиоход ашигласан геодези, зураг зүйн суурь өгөгдөл, мэдээлэл болон хэмжилт зураглалын ажил;
- инженерийн барилга байгууламжийн төлөвлөлт, байгуулалтад ашигласан геодези, зураг зүйн суурь өгөгдөл, мэдээлэл болон хэмжилт зураглалын ажил.

# ТАВДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО

27

## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

| МЭДЭЭЛЛИЙН САН | НИЙТ |
|---|---|
| ГАЗРЫН ЗУРГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН | АГААР, САНСРЫН ЗУРАГ, БАЙР ЗҮЙН ЗУРАГ, НЭГ МАЯГИЙН СУУРЬ, СЭДЭВЧИЛСЭН ГАЗРЫН ЗУРАГ, АТЛАС |
| ГЕОДЕЗИЙН СҮЛЖЭЭНИЙ ЦЭГ ТЭМДЭГТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН | 22977 ЦЭГ /БАЙРЛАЛ, ӨНДӨР, ГРАВИМЕТРИЙН СҮЛЖЭЭ, 43 БАЙНГЫН АЖИЛЛАГАТАЙ СТАНЦ/ |
| ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН | 214805 БАТЛАГДСАН НЭР |
| ХИЛИЙН ЦЭСИЙН МЭДЭЭЛЛИЙН САН | УЛСЫН ХИЛИЙН ХИЛИЙН ТЭМДЭГТИЙН СОЛБИЦОЛ, ӨНДӨР, ХИЛИЙН ЦЭС 8252.6 КМ |
| ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН БАГАЖНЫ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН | 11 ТӨРЛИЙН 2100 БАГАЖНЫ МЭДЭЭЛЭЛ |
| ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН МЭРГЭЖИЛТНИЙ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН САН | 300 ГАРУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, 3000 ГАРУЙ ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭД |



## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН НЭГДСЭН САН ХӨМРӨГ

- **НЭГДСЭН САН**

геодезийн сүлжээний, газрын зураг, агаар, сансрын зураг, газар зүйн нэр, геодезийн цэг, тэмдэгт, тэдгээртэй холбогдох бусад тоон баримт мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан нь төрийн өмч байна.

- **НЭГДСЭН САНД ШИЛЖҮҮЛЭХ ҮҮРЭГ**

улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагын хэрэгжүүлж байгаа төслийн хөрөнгө, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт, хэвлэмэл болон тоон зураг, бичлэг, тоон мэдээллийг нэгдсэн санд шилжүүлэх үүрэгтэй.

- **НЭГДСЭН ПОРТАЛ САЙТААР ДАМЖУУЛЖ, НЭЭЛТТЭЙ ХҮРГЭХ ҮҮРЭГ**

Геодези, зураг зүйн өгөгдөл, бүтээгдэхүүнийг нэгдсэн портал сайтаар дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэнэ.

- **30 ХОНОГТ ШИЛЖҮҮЛЭХ ҮҮРЭГ**

27.4.2-д заасан мэдээллийг мета-өгөгдлийн хамт ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор геодези, зураг зүйн мэдээлийн улсын нэгдсэн санд шилжүүлэх үүрэгтэй.

- **НЭГДСЭН СИСТЕМЭЭС НЯГТЛАХ ҮҮРЭГ**

газрын зураг захиалж хийлгэхдээ урьд өмнө нь тухайн газар нутагт геодези, зураг зүйн ажил хийгдэж байсан эсэхийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн системээс нягтална.

# ЗУРГААДУГААР БҮЛЭГ. САНХҮҮЖИЛТ, ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРИУЦЛАГА

## 29 САНХҮҮЖИЛТ

- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖЛЫГ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР САНХҮҮЖҮҮЛНЭ.
- **УЛСЫН ТӨСӨВ:**
  - Улсын геодезийн сүлжээ байгуулах, нягтруулах, давтан хэмжих,
  - геодезийн байнгын цэг, тэмдэгтийг тоолох, нөхөн сэргээх,
  - дунд болон жижиг масштабын байр зүйн зураг, сургалтын, сэдэвчилсэн газрын зураг, атлас, Үндэсний атлас зохиох, шинэчлэх, хэвлэх,
  - норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, хэвлэх, сурталчлах
- **ХОЛБОГДОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА**
  - Тухайн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч
- **ОРОН НУТГИЙН ТӨСӨВ /ЗАХИАЛАГЧ: ЗАСАГ ДАРГА/:**
  - Том масштабын байр зүйн болон дэвсгэр зураг зохиох, шинэчлэх,
  - геодезийн сүлжээ байгуулах, байнгын цэг тэмдэгтийг хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх
  - Тухайн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч
- **ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА :**
  - Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, гудамж, зам, талбай, шугам сүлжээний холболт, мод цэцэрлэгжүүлэлтийг шинээр хийх, өөрчлөх, нөхөн сэргээх зэрэг газар шорооны ажил хийсэн талбайд гүйцэтгэлийн зураг хийлгэх

## 30 ХАРИУЦЛАГА

- **ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИАР**

Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

- **ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ЭСХҮЛ ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАР**

Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## 31 ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

## 32 ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

## 20 АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЧИГ ҮҮРЭГ

20.1.2.
- НУТАГ ДЭВСГЭРТЭЭ ХАМААРАХ БАЙР ЗҮЙН ЗУРАГ, ЗУРАГ ЗҮЙН БҮТЭЭЛД ТУСГАГДАХ **ГАЗАР ЗҮЙН НЭР, ХИЛ, ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН БОЛОН ӨӨРЧЛӨГДСӨН ОБЪЕКТЫН** ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ,
- НУТАГ ДЭВСГЭРТЭЭ ХАМААРАХ ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ, ТЭМДЭГТИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ, ЖИЛ БҮР ТООЛЛОГО ХИЙЖ ТАЙЛАНГ ДАРАА ЖИЛИЙН **2 ДУГААР САРЫН 1-НИЙ** ӨДРИЙН ДОТОР ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД МЭДЭЭЛЭХ;

20.1.3.
- ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАРЬЯА НУТАГ ДЭВСГЭРТ НЬ ХИЙЖ БАЙГАА ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН **АЖИЛД ХЯНАЛТ ТАВИХ;**

20.1.4.
- НУТАГ ДЭВСГЭРТЭЭ ХАМААРАХ БАТЛАГДСАН **ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ХЭРЭГЛЭЭНД** ХЯНАЛТ ТАВИХ, ШИНЭ НЭРИЙН ТАЛААР **САНАЛ ГАРГАХ;**

20.1.5.
- НУТАГ ДЭВСГЭРТЭЭ ХАМААРАХ ГАЗРЫН ЗУРГИЙГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗУРГААР ШИНЭЧЛЭХ АЖЛЫГ **ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ;**

20.1.6.
- ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ ГЕОДЕЗИ, ГАЗРЫН ЗУРГИЙН АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТӨСЛИЙГ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААР **ХЯНУУЛАХ, ХАМТРАН БАТЛАХ;**

20.1.7.
- ЭНЭ ХУУЛИЙН 10.10, 10.11-Д ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ, ТЭМДЭГТИЙГ **ДӨРВӨН ЖИЛ** ТУТАМ ТООЛОХ, БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ;

20.1.8.
- ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨР ГҮЙЦЭТГЭСЭН ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АЖЛЫН ҮР ДҮНД **ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХИЙЛГЭХ;**

20.1.9.
- НУТАГ ДЭВСГЭРТЭЭ **ХАМААРАХ ТОМ МАСШТАБЫН** ГАЗРЫН ЗУРГИЙН ЖИЖҮҮРЛЭЛТИЙН ЗУРГИЙГ ХӨТЛӨХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ





1. ГАЗРЫН ЗУРГИЙГ ЗОРИУЛАЛТААР НЬ 2 АНГИЛЖ, НИЙТЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ БҮРДҮҮЛСЭН.
2. ГЕОДЕЗИЙН ЦЭГ, ТЭМДЭГТ ИХЭЭХЭН УСТАЖ БАЙГАА УЧРААС ХУУЛИАР ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСЫН ХЭМЖЭЭГ ТОГТООЛОО.
3. ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН ХИЛИЙН ШУГАМЫН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ СОЛБИЦОЛЖУУЛАХААР ТУСГАСАН.
4. ХУУЛИАР ЗОХИЦУУЛААГҮЙ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДЫГ НЭМЖ ОРУУЛСАН.
5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРГИЙГ ТОДОРХОЙ БОЛГОСОН, ТББ-ЫН ОРОЛЦООГ НЭМСЭН.
6. ГАЗАР ЗҮЙН НЭРЭНД ХАМААРАХ ОБЪЕКТЫН НЭРИЙГ АНГИЛСАН.
7. ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ, МАГАДЛАЛ, МАГАДЛАН ХЭМЖИЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХУУЛЬЧИЛСАН.
8. ГЕОДЕЗИЙН СҮЛЖЭЭ, ГАЗРЫН ЗУРГИЙН ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ ХУГАЦААГ ОРУУЛСАН.
9. ГАЗРЫН ЗУРГИЙН АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТЫГ ТОДОРХОЙЛСОН.
10. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ НИЙЦҮҮЛЖ, НАРИЙВЧИЛСАН.
11. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН НОРМ НОРМАТИВИЙН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОСОН.
12. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ НЬ ҮНДЭСНИЙ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН СУУРЬ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БАЙХААР ТУСГАСАН.



Намайг уншуул!

Та дээрх QR кодыг уншуулж

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд

саналаа өгөх боломжтой.